

ТҮВШИНШИРЭЭ СУМЫН 2022 ОНЫ 2 ДУГААР САРЫН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭ

Төрийн удирдлагын чиглэлээр:

Сумын ИТХ-ын 2 дугаар сарын 17-ны 05 тоот шийдвэрийн дагуу багийн иргэдийн нийтийн хурлууд товлогдон, товын дагуу зохион байгуулагдаж байна. Багийн иргэдийн нийтийн хурлаар сумын Засаг дарга 2021 онд суманд хийгдсэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын тайлан, багийн Засаг дарга нар 2021 онд хийсэн ажлын тайлан, ЗТДГ-ын мэргэжилтнүүд болон соёлын төвийн мэргэжилтнүүд өөрт холбогдох чиглэлийн дагуу мэдээ мэдээлэл өглөө. Өлзийт багийн иргэд хурлаараа сумын хил зааг нутгийн өвөлжөөний газрыг эзэмшүүлэх асуудлыг дэмжиж буйгаа илэрхийлсэн.

Сумын 80-аас дээш настай 18 ахмад настанд сумын Засаг дарга гарын бэлэг гардуулж, хүндэтгэл үзүүллээ. ЗДНС-аас 900,0 мянган төгрөг зарцуулсан.

“Алдарт эх”-ийн одонгийн материалыг холбогдох журмын дагуу бүрдүүлэн, иргэдээс хүлээн авч, ЗДТГ-т нэгтгэж байна. Одоогоор 10 эхийн материал хүлээн аваад байна.

Төрийн дээд шагналаар шагнагдах 4 иргэний тодорхойлолтыг холбогдох газарт хүргүүлж, 1 иргэн Монгол Улсын Төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор шагнагдсан.

COVID-19 вирусээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагууд дотоод цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал халдваргүйжүүлэлт, агааржуулалтыг өдөр бүр тогтмол хийж байна.

2022 оны 02 дугаар сарын байдлаар сумын нийт суурин хүн ам 3422, өрх 983, хүн ам, өрхийн мэдээллийн цахим санд хяналт тавьж ажиллаж байна. Шинээр төрсөн 0, нас барсан 8 хүн бүртгэгдсэн.

Аймгийн Засаг даргын 2020 оны 06 дугаар албан даалгаврын хүрээнд сар бүрийн 24-ний өдрийн дотор “Хариу арга хэмжээний тайлан”-г “Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт хүргүүлж байна.

2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргын албан бичгийн хүрээнд сумын төвийн уяачдад бэсэргээ, сунгаа хийхгүй байх талаарх мэдэгдлийг хүргүүлсэн.

2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн Өлзийт багийн хурлаар ард иргэдэд мэдээ мэдээлэл хийж Хүүхэд хамгааллын тухай хууль болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудаар гарын авлага бэлтгэн тараалаа.

Хүүхэд хамгааллын статистикийн тоон үзүүлэлт авах маягтын дагуу хагас өнчин, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, уралдаанч хүүхэд, байранд амьдардаг хүүхэд, эцэг, эхтэйгээ амьдардаг хүүхдүүдийн судалгааг гарган холбогдох газарт хүргүүлсэн.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Сар бүрийн 8-ны дотор шилэн дансанд байгууллагуудын сарын төсөв гүйцэтгэл, орон нутгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл, ОНХСангийн төлөвлөгөө гүйцэтгэл бусад мэдээ мэдээллийг шивж байна.

Нийгмийн даатгалын НД 8, НД7 /ажиллагсдын цалин тооцооны хуудас/ тайлангууд мөн татварын ТТ 11, ТТ 12 буюу үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутган тооцсон татварын тайлангуудыг гарган интернетэд шивэн цахимаар илгээсэн.

Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлан гаргалт болон онлайн шивэлтэд анхааран хяналт тавин ажилласан бөгөөд бүх аж ахуйн нэгжүүд тайлангаа хуулийн хугацаанд онлайн програмд шивэн илгээж, тайлангууд нь баталгаажсан байна.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Аймгийн ХААГ-т 7 хоног бүрийн 3 дахь өдөр өгдөг төл бойжилт, зүй бус хорогдлын мэдээгээр сумын хэмжээнд том малын хорогдолгүй байна.

2022 онд шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хамрагдах малын тоо, шаардагдах зардлын тооцоог гаргаж холбогдох газар хүргүүллээ. 3 сар гаргаад сумын үхэр сүрэгт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт хийхээр вакцин захиалгыг хүргүүлсэн.

Агаар бохирдуулагчийн эх үүсвэрийн нэгдсэн тооллого 1 сарын 26-28-ны хооронд хийж дуусгаж, Орчны бохирдлын эх үүсвэр хаягдлыг тооллогын мэдээллийн санд оруулсан.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАЛАМЖ: Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан /LMIS/-д шинэ ажлын байр-1, ажил зуучлал-9 нийт 10 иргэний мэдээллийг бүртгэсэн.

2022 оны 02-р сард 2020-2021 онд төсөл хөтөлбөрт хамрагдсан хөтөлбөрт хамрагдсан 9 иргэн хуваарийн дагуу 1100,000 төвлөрүүлэхээс 5 иргэн 900,000 төгрөгийн ХЭДС-ийн 100120037010 тоот дансанд төвлөрүүлсэн.

53 хүүхдийн мөнгөө бэлнээр авах хүсэлтийг программд хүсэлтийг гаргасан.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд хамрагдсан 8 иргэнд 854548 төгрөгийн мэдээллийг "Нөхөн олголтын" жагсаалтаар гарган бэлтгэн өгч нөхөн олгуулсан.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний олголтыг гэрээт дэлгүүрээр 5 өрхөд олголтыг хийж байна. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ халамжаас хөдөлмөрт хүрээнд хамрагдаж байгаа өрхийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, иргэдийн дэлгэрэнгүй судалгаагааг маягтын дагуу гарган хүргүүлсэн.

02-р сард Нийгмийн халамжийн ehalamj системд Нийгмийн халамжийн тэтгэврийн сунгалт 6 иргэн, Цалинтай ээж хөтөлбөрийн 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжид 8 иргэнд, Жирэмсэн эхийн тэтгэмжид 7 иргэнд, ХБИ-ний түлээний хөнгөлөлт-7 нийт 28 иргэний мэдээллийг бүртгэж тэтгэвэр тэтгэмжид хамруулсан.

НИЙГМИЙН ДААТГАЛ: Эрүүл мэндийн даатгалд 36 хүний 2228400 төгрөг , сайн дурын даатгалд 42 хүний 2628450 төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 8 байгууллагын 1251900 төгрөгийн орлого орсон. 2 дугаар сарын тэтгэвэрт 2 банкаар дамжуулан 416 хүнд 203938763 сая төгрөгийн тэтгэвэр олгосон. Оршуулгын тэтгэмжид 1 хүнд 1000,0 төгрөг олгосон. Шинээр 8 иргэний тэтгэврийн материал хүлээн авч, 4 иргэний тэтгэвэр тогтоогдож, 1 иргэний тэтгэврийн материал хяналтад байна.

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР: 2022 оны 2-р сарын 14-ний өдрөөс эхлэн хичээлийн жилийн 2-р улирлын сургалтын ажил БШУСайдын 2019 оны 8-р сарын 01-ний өдрийн А/497 дугаар тушаалын дагуу хичээллэж байна. Дунд, ахлах анги 305 хүүхэдтэй танхимаар хичээллэж байна. Үдийн өмнө 8-12-р ангийн 181 хүүхэд, үдийн хойно 6,7-р ангийн 124 хүүхэд хичээллэж байна. Энэ улирлаас мэргэжлийн орос хэлний багш ажиллаж байна.

ЭЕШ-д бэлтгэх Elab байгууллагатай хамтран ажиллахаар болж ЭЕШ өгөх 24 хүүхдийн төлбөрийн асуудлыг зохих байгууллагад хандаж 100% хамрагдахаар боллоо. 1.200.000 төгрөгийг сурагчид өөрсдөө, 1 сая төгрөгийг сумын Засаг дарга, 600.000 төгрөгийг Аймгийн Засаг дарга, 600.000 төгрөгийг сургуулийн захиргаанаас гаргаж ЭЕШ-д бэлтгэж байна.

Мэргэжлийн багш нартай хамтарч CCV, болон 1-р улирлын үнэлгээ болон асуулгын хоцрогдлын судалгааг гаргахад агуулгын хоцрогдол 25-48%-ийн ахицтай байна. Өөрийн сургуулийн CCV-г аймаг улсын CCV-тэй харьцуулан агуулгын хоцрогдлын судалгааг гаргасан. Манай сургууль аймаг, улсын CCV-тай харьцуулахад зарим судлагдахуун 1.2-2.8%-иар доош зарим судлагдахуун 1.6-3.1%-иар доошоо байна. ЭЕШ өгөх сурагчдаас аймгийн БШУГазраас сорил шалгалтыг авч эхэлсэн. Монгол хэл-15, математик-14, Англи хэл-7, Нийгэм-20, Биологи-3, Хими-1, Физик-3 сурагч сорилтод хамрагдаад байна. Улсын шалгалтад амжилттай бэлтгэх зорилготой 9-р ангийн улсын шалгалттай 7 судлагдахууны давтлагыг хуваарь гарган ажиллаж байна. Мөн багш нарын хичээлд сургуулийн удирдлагууд сууж арга зүйн зөвлөгөө өгч байна.

"Ковид ба Боловсрол" улсын хэмжээний Онлайн эцэг эхийн уулзалт 2022.02.10-ны өдрийн 19:00 цахимаар зохион байгууллаа. Энэхүү ZOOM арга хэмжээнд сургууль, цэцэрлэгийн эцэг эхийн зөвлөлийн дарга нар, сургуулийн нийгмийн ажилтан, цэцэрлэгийн багш нар хамрагдлаа.

"Хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулахад эцэг эх, асран хамгаалагчийн оролцоо дэмжлэг" сэдвийн хүрээнд Эцэг эхийн үүрэг оролцоо, Ковид-19 дэгдэлтийн үед эцэг эх хүүхдийнхээ сэтгэл зүйг дэмжих нь, Цахим хэрэглээнд анхаарах нь гэсэн 3 дэд сэдвийн хүрээнд Цахим сургалтад зохион байгууллаа. Тус цахим сургалтад 93 эцэг эх хамрагдлаа.

Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн, эрдэмтэн зохиолч Д.Маамын мэндэлсэн өдрийг тохиолдуулан зохиолчийн зохиол бүтээлийг нийтэд сурталчлах, цахим орчинд түгээн дэлгэрүүлэх ажлын зохион байгуулж байна. Үүнд: Д.Маам зохиолчийн үр хүүхдүүдээс сургуулийн сурагчдад бэлэглэсэн 400 гаруй номын үзэсгэлэнг зохион байгуулах, 1-2 дугаар ангийн сурагчдын дунд Д.Маам зохиолчийн анхны шүлэг болох "Мөнгөн өвөл", "Хавар", "Зун", "Намар" шүлгүүдээс сонгож анги нийтээрээ уран унших, 3-5 дугаар ангийн сурагчид анги нийтээрээ "Тархинд хийсэн аян" зохиолын Мөнхөөгийн дууг сурах, 6-9 дүгээр ангийн сурагчид Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн, эрдэмтэн зохиолч Д.Маамын шүлгүүдээс сонгож анги

нийтээр уран яруу уншиж сурах, 10-12 дугаар ангийн сурагчид Д.Маам зохиолчийн зохиосон “ДУНГААМАА” дууг хэн сайн дуулах вэ? ганцаарчилсан цахим уралдааныг тус тус зохион байгууллаа.

Сургуулийн анги бүлгийн эцэг эхчүүдийн төлөөллийг сургууль орчмын гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор SCHOOL POLICE эргүүлийн үүргийг гүйцэтгүүлэхээр төлөвлөлт гарган ажиллаж байна. Монгол улсын Ерөнхий сайдын санаачлага "Илүүдэл жингүй-Эртэч монгол"-д Түвшинширээ сумын ЕБС-ийн багш, ажилчид дасгал хөдөлгөөнөөр нэгдлээ.

Сүхбаатар аймгийн Нийтийн номын сангаас зохион явуулж буй “Судар эгшиглэн” төсөлд багш, ажилтан албан хаагчид хамрагдах ажлыг зохион байгуулж байна.

Хүүхдийн цэцэрлэгт 3-5 насны 197 хүүхэд хамрагдаж байна. 2 нас хүүхдийн элсэлтээр 2 настай 25 хүүхэд бүртгүүлж, 2 дугаар сарын 25-аас эхлэн цэцэрлэгт явахаар болоод байна.

Байгууллагын дотоод хяналтын баг хичээл сургалтын үйл ажиллагаа эхлэхтэй холбогдуулан агуулахын хүнсний нөөц, татан авалт, махны шинжилгээний бичиг зэрэгт хяналт тавьсан.

Мөн бүлгүүд болон байгууллагад их цэвэрлэгээ хийлгэж, тандалтын баг, ХАБ-ын ажлын хэсэгтэй хамтран 1 удаа шалгалт хийсэн. Мөн Хоол хүнсний чанар аюулгүй байдал, эрүүл ахуй, ариутгал, халдваргүйтэлд, бүлгүүдийн цэвэрлэгээ, ариутгал бичиг баримтын хяналт шалгалтыг тусгай удирдамжийн дагуу 1 удаа хийсэн. Шалгалтаар илэрсэн зөрчил болон өгсөн үүрэг чиглэлийн дагуу биелэлтийг 1 удаа шалгалаа.

Байгууллагын тандалтын баг өглөө хүлээн авах, оройн тарах үеэр хүүхдийн биеийн халууныг тогтмол үзэж, тусгай тэмдэглэл хөтлөх, багш ажилчдын биеийн халууныг тогтмол үзэх, цаг бүртгэх, багш ажилчид хүүхдийн QR код уншуулах, гаднаас орсон хүнийг тогтмол хянах зэрэг ажлуудыг хийсэн. Мөн Дотоод хяналт, ХАБ-ын ажлын хэсэгтэй хамтран 2 удаа шалгалт хийж, ХАБ-ын 9-10 зөрчил илрүүлж, үүрэг чиглэл өгч, зөрчлийг 100 арилгуулж, биелэлтийг шалгалаа.

Цэцэрлэгийн хүүхдүүдийг эрсдэлээс сэргийлэхийн тулд бүлгийн хүлээн авалт, таралтыг цагийн хуваарийн дагуу “Гараас гарт” журмыг баримтлуулан ажиллаж байна. Мөн хүүхдийг “ГЭР- ЦЭЦЭРЛЭГ- ГЭР” маршрутыг мөрдүүлэхийг

зөвлөж байна. Үүний үр дүнд хүүхэд аливаа эрсдэлээс сэргийлэгдэж, эцэг эх багшийн уялдаа холбоо сайжирч, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжиж байна.

СОЁЛЫН ЧИГЛЭЛЭЭР: Соёлын төвөөс хүүхэд багачуудыг авьяас чадварыг нээн хөгжүүлэх 5 чиглэлийн дугуйлан хичээллүүлэхээр бүртгэл хийж байна. 3 дугаар сарын 1-ээс дугуйлангууд хичээллэж эхэлнэ.

Судар эгшиглэн төслийн хүрээнд сумын иргэд, албан хаагчид, хүүхдүүдийг уг төсөлд идэвхтэй хамруулах үйл ажиллагаа явуулж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР: Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа нь жигд хэвийн явагдаж байна. Амбулаторийн нийт үзлэг 163, алсын дуудлага 14, гэрийн дуудлага 4, хэвтэн эмчлүүлэгч 30, хэвтэн эмчлүүлэгч Ковид /Халдвартай бүс/ - хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөн байхгүй.

2 дугаар сард Ковид-19 цар тахлын эсрэг вакцинжуулалтын 1-р тунд 34 хүн, 2-р тунд 4, 3-р тунд 45, 4-р тунд 50 хүн хамрагдаад байна. Мөн сар болгон хийгддэг товлолын вакциныг 56 хүүхдэд хийгээд байна. Багийн хурлууд зарлагдсантай холбоотой багийн эмч болон вакциначуурын хамт багуудаар ажиллаж байна. Хурлын үеэр “Эрчүүдийн эрүүл мэндийн төлөө хамтдаа” аянд нийт 79 хүн хамрагдсан байна. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлага, дадлыг бий болгох зорилготой "Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн төлөө хамтдаа" аян сумын хэмжээнд зохион байгуулагдаж байна.

2 дугаар сард эх барих эмэгтэйчүүдийн үзлэгт 70 хүн хамрагдаж зөвөлгөө зөвлөмж авсан. Тухайн сард лабораторийн хийсэн шинжилгээ үйлчилгээ: сахар – 14, Серологи – 2, Шээс – 25, Ковид -59, Биохими -1, Элэгний В, С вирусийн шинжилгээнд – 5 хүн тус тус хамруулаад байна.

Тайлан нэгтгэсэн:

ХЭЗХМэргэжилтэн Ш.Дүүрэнбилэг

Хянасан:

Тамгын газрын дарга Ц.Ренчинмядаг